



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ
“ГАН ХИЙЦ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 14-ны
өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Г Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай Г

Компанийн тухай хуулийн 76.1.2 дугаар зүйл, компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02-р сарын 14-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 11:40 цагаас компанийн хурлын танхимд хуралдуулахаар зарласугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг баталсугай. Үүнд:
 - Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Ногдол ашгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв, Компанийн 2025 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтын дагуу баталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

М.ДАВААСҮРЭН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

П.ТӨВСАНАА

Э.ДОЛГОРСҮРЭН

Ц.ХАНГАЙ

Б.ГАНТУЛГА

Б.ЭРДЭНЭБАЯР

Б.ГАНБАТ

Д.ОЮУНЗУЛ

О.УУГАНЦЭЦЭГ

“ГАН ХИЙЦ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажлын утга	Хугацаа	Хариуцах хүн
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржд хүргэх	2025-02.17	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
2	Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр нийтлэх	2025.02.21	Ерөнхий нягтлан бодогч Х.Ариунсанаа
3	Олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар мэдээлэх /Өглөөний сонин, Өдрийн сонин, UBS телевиз, www.Gankhiits.mn www.mse.mn /	2025-02-19 Давтан зар 2025-03-06	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
4	Хурлаар хэлэлцэх асуудлыг бэлэн болгох Үүнд: <ul style="list-style-type: none">- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах; КТ 62.1.9- Ногдол ашгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв, Компанийн 2025 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах КТ 62.1.13- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох КТХ 62.1.7	2024-03-13	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
5	Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг Үнэт цаас төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс авч бэлтгэх	2025-03-13	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг

6	Хурлын байрыг бэлдэх	2025-04-25	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
7	Компанийн үйл ажиллагааны тайлан, компанийн засаглалын жилийн тайланг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэх	2025.04.27	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
8	Хурлын ирцийг бүртгэн, гишүүдэд хурлын материалыг тараан танилцуулах	2025-04-25	Тооллогын комисс
9	Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэх	2025-04-27	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ
“ГАН ХИЙЦ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 14-ны
өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Г Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Г

“Компанийн тухай” хуулийн 46.5, 46.6 дугаар зүйл, “Компанийн дүрэм”-ийн 10.5 дах заалт, компанийн ногдол ашгийн бодлогын 2.3 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02-р сарын 14-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2024 оны компанийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.


2. Ган хийц ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан -6,584,641.84 төгрөгийн алдагдалтай гарсан тул 2024 оны үйл ажиллагаанд ногдол ашиг хуваарилахгүйгээр тогтоосугай.

3. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Даваасүрэн-д даалгасугай.

4. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Даваасүрэн-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮН


М.ДАВААСҮРЭН

П.ТӨВСАНАА

Э.ДОЛГОРСҮРЭН

Ц.ХАНГАЙ

Б.ГАНТУЛГА

Б.ЭРДЭНЭБАЯР

Б.ГАНБАТ

Д.ОЮУНЗУЛ

О.УУГАНЦЭЦЭГ